

**БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2026 оны 06 дугаар сарын 02

Рашаант

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
<p align="center"><b>ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.3.1,4.3.1.5,4.3.3.6, Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө/</b></p>							
<p align="center"><b>ЗОРИЛТ1. ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛНЭ.</b></p>							
1.1.	Иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх	-	Иргэн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ авсан хувь	100	100	1.Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр; төрсний бүртгэл 518, гэрлэсний бүртгэл 97, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 44, үрчилсний бүртгэл 11, эцэг /эх/ тогтоосны бүртгэл 30, овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 40, иргэний үнэмлэх олгосны бүртгэл 1558, нас барсны бүртгэл 187, регистрийн дугаар өөрчилсний бүртгэл 5, гадаад паспортын бүртгэл 1593, иргэнд олгосон лавлагаа 2738, тоон гарын үсэг олголтын бүртгэл 4556, нийт 11377 бүртгэл бүртгэгдсэн байна. 2.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр; газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл 186, газар өмчлөх эрхийн улсын бүртгэл 74, худалдах худалдан авах гэрээ 323, бэлэглэх гэрээ 30, гэрээслэл, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл 47, хамтран өмчлөгч өөрчлөгдөх гэрээ хэлцэл 64, барьцааны гэрээ 1327, лавлагаа мэдээлэл өгөх 33, барьцааны эрх дуусгавар болсны бүртгэл 1154, бүртгэлд өөрчлөлт оруулах бүртгэл 172, хувийн хэрэг хаах 95, нийт 3505 бүртгэл бүртгэгдсэн байна.	100

1	2	3	4	5	6	7	8
						3.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр; төрийн бус байгууллага 14, хоршоо 15, ХХК 60, нөхөрлөл 12, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулсан бүртгэл 136, гэрчилгээ дахин олголт 22, хуулийн этгээдийн нэр баталгаажуулалт 299, хуулийн этгээдийн тамга, тэмдгийн хяналтын хуудас олгосон бүртгэл 118, хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдгийн бүртгэл 17, нийт 693 бүртгэл бүртгэгдсэн байна.	
1.2	Улсын бүртгэлийн мэдээллийн цахим сангаас төрийн болон хууль хяналтын байгууллагад мэдээлэл, лавлагаа, хуулбар олгох.	-	Албан бичгээр олгосон мдээлэл, лавлагаа хуулбарын олгосон хувь	100	100	Улсын бүртгэлийн мэдээллийн цахим сангаас төрийн болон хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу 147 удаагийн албан бичгээр иргэний улсын бүртгэлтэй холбоотой 286, хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой 6, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 17, нийт 309 төрлийн лавлагаа, хуулбар олгосон байна.	100
1.3	Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шинэчлэн боловсруулах шаардлагатай дүрэм, журмын төсөлд санал хүргүүлэх	-	Эрх зүйн актын төсөлд санал хүргүүлсэн тоо	4	4	УБЕГ-аас ирүүлсэн Нийтийн зориулалттай барилгын дундын өмчлөлийн эд хөрөнгийн удирдлагын тухай хуулийн төсөлд 6 саналыг өөрчлөх үндэслэл шаардлага, тайлбарын хамт хэлстийн даргын 2026 оны 02 дугаар сарын 26-ний өдрийн 11/130 дугаарт албан бичгээр болон u.unerlkhamb@burtgel.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн байна.	100
1.4	Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор контент бэлтгэж, түгээх	-	Бэлтгэсэн контентын тоо	25	40	Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор 16 нас хүрч иргэний үнэмлэх шинээр авах, 25, 45 насны сунгалтын бүртгэлийн хугацаа хэтрүүлэн зөрчлийн хэрэг үүсгүүлэхээс урьчилсан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээний хүрээнд 2 төрлийн постер, Тоон гарын үсэг олгох тухай 1 контент бэлтгэж түгээлээ. Мөн УБЕГ-аас бэлтгэсэн 38 мэдээллийг хуваалцаж, түгээсэн байна.	100
1.5	Хэлтсээс улсын бүртгэлийн Дөт киоск машинаар үйлчилгээ үзүүлэх	-	Хүсэлт шийдвэрлэгдсэн хувь	100	100	Иргэний улсын бүртгэлийн лавлагаа үйлчилгээ 1462, тоон гарын үсэг олголт 813, хуулийн этгээд болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 62 лавлагаа, нийт 2337 үйлчилгээ үзүүлсэн байна. Тус киоск машин 1 дүгээр сарын 13-ны өдөр үйлчилгээ үзүүлж байх явцдаа эвдрэл гарсан тул УБЕГ-т 11/38 тоот албан бичгээр засуулах хүсэлтийг хүргүүлж, засагдаж авч	100

1	2	3	4	5	6	7	8
						ирснээр 4 дүгээр сарын 07-ны өдрөөс ашиглалтад орсон болно.	
1.6	Өлзийт суманд улсын бүртгэлийн Дөт киоск машин байршуулж, үйлчилгээ үзүүлэх		Хүсэлт шийдвэрлэгдсэн хувь	-	100	Өлзийт суманд Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн Хурдан киоск ажилладаг тул Дөт машин суурилуулах асуудлыг УБЕГ-ын даргатай ярилцаж түр хойшлуулсан болно. Харин тус суманд улсын бүртгэлийн явуулын үйлчилгээг сар бүрийн тогтмол 1 өдөр үзүүлж байхаар Өлзийт сумын ЗДТГ-ын даргатай зөвшилцөн, холбогдох төлөвлөгөө гарган ажиллаж байна.	100
<b>ЗОРИЛТ 2. ОРЧИН ҮЕИЙН ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЖ, ТӨРӨӨС ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ЧАНАР, ШУУРХАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.</b>							
2.1	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, тулгалт хийх ажлыг үе шаттайгаар хийх ажлыг үргэлжлүүлэх	-	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд зөрүүтэй орсон, алдаатай орсон мэдээллийг засч оруулсан тоо	710	800	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, тулгалт хийх ажлын хүрээнд цахим санд мэдээлэл зөрүүтэй, алдаатай орсон, нотлох баримтын хуудас өмнө хойноо орж цахимжсан гэх 51 хувийн хэргийн зөрүүтэй, алдаатай орсон мэдээллийг зассан байна.	30
2.2	Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд зөрүүтэй, алдаатай, буруу орсон мэдээллийг засах, нэмэлт өөрчлөлт хийх замаар бүртгэл үнэн зөв байх зарчмыг хангах		Хүсэлтийг шийдвэрлэсэн хувь	100	100	Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд зөрүүтэй, алдаатай, буруу орсон мэдээллийг засах, нэмэлт өөрчлөлт хийлгүүлэхтэй холбоотойгоор иргэдээс 554 хүсэлт ирснээс 546 хүсэлтийг нөхөн болон нэмэлт өөрчлөлтийн бүртгэл хийгдэж шийдвэрлэсэн бол 8 хүсэлт судлагдаж байна. Харин Иргэний улсын бүртгэлийн газраас нас барсны бүртгэлтэй холбоотой цахим санд нэмэлт өөрчлөлт өөрчлөлтийн бүртгэлээр засаж, залруулах 123 мэдээлэл ирүүлснийг шалгаж, 119 мэдээллийг санд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр зөв болгож залруулсан, харин огт мэдээлэл нь олдохгүй 4 иргэний мэдээлэл шалгагдаж байна. 2025 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд цахим санд нөхөн бүртгэл 357, нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 683, нийт 1040 бүртгэл бүртгэгдсэн байна.	100
			Нэмэлт өөрчлөлт хийсэн бүртгэлийн тоо	964	1200		

1	2	3	4	5	6	7	8
						Нөхөн бүртгэлийг бүртгэлийн төрлөөр ангилвал; төрсний бүртгэл 214, гэрлэсний бүртгэл 95, үрчилсний бүртгэл 4, овог нэр өөрчилсний бүртгэл 3, нас барсны бүртгэл 38, эцэг /эх/ тогтоосны бүртгэл 1; Нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг бүртгэлийн төрлөөр илэрхийлвэл; төрсний бүртгэл 225, үрчилсний бүртгэл 11, гэрлэсний бүртгэл 80, нас барсны бүртгэл 58, үндсэн сангийн нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 304 байна.	
2.3	Зорилтод бүлгийн үйлчлүүлэгчид улсын бүртгэлийн явуулын үйлчилгээ үзүүлэх		Зорилтод бүлгийн иргэдэд үзүүлсэн үйлчилгээ үзүүлсэн хувь	100	100	Улсын бүртгэлийн явуулын үйлчилгээг улсын бүртгэгчгүй болон хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөгддөггүй сумдыг онцлон Нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг зохион байгуулж, явуулын үйлчилгээ үзүүллээ. 1.Бууцагаан суманд 05 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд ажиллаж, иргэний улсын бүртгэлийн 13, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 1, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 27, нийт 41 бүртгэл хийж, 16 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, “Улсын бүртгэлийн цахим шилжилт, цаашдын зорилго” сэдэвт сургалт зохион байгууллаа. Сургалтад 35 иргэн хамрагдав. 2.Өлзийт суманд 05 дугаар сарын 18-ны өдөр ажиллаж, иргэний улсын бүртгэлийн 27, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 1, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 21, нийт 49 төрлийн үйлчилгээ үзүүлж, 15 иргэнд зөвлөгөө мэдээлэл өглөө. Политехник коллеж, Эрдэм ахлах сургууль, 12 дугаар цэцэрлэг зэрэг төрийн байгууллагууд дээр явуулын үйлчилгээ үзүүлсэн бөгөөд гадаад паспортын бүртгэл 4, иргэний үнэмлэхний захиалга 4, тоон гарын үсэг олголт 21, лавлагаа 3 үйлчилгээ тус тус үзүүлсэн байна.	100
2.4	Хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын тооллогыг зохион байгуулах	-	Гүйцэтгэлийн хувь	-	100	Хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын тооллогыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган, хэлтсийн даргаар 2026 оны 04 дүгээр сарын 15-нд батлуулан, төлөвлөгөөний дагуу тооллогыг 15 хоногийн хугацаанд 100 хувийн гүйцэтгэлтэйгээр зохион байгууллаа. Тооллогод 145312 хуудас бүхий 3233 хувийн хэрэг тоологдлоо.	100

1	2	3	4	5	6	7	8
						Тооллогын ажлын гүйцэтгэлийн тайланг УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон УБНА-ын газарт тус тус хүргүүлэхээр бэлтгэж байна.	
2.5	Баянхонгор аймгийн 1987 онд төрсөн иргэдийн төрсний бүртгэлийн мэдээллийг Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулах		Мэдээлэл оруулсан хувиар		100	Хугацаа болоогүй буюу 3-р улиралд хийхээр төлөвлөгдсөн.	
<b>ЗОРИЛТ 3. УЛСЫН БҮРТГЭЛ БОЛОН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛНА.</b>							
3.1	Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах, хэрэгжилтийг хангах		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	87.5	100	Хэлтсийн Хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хяналтын шалгалтын төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг төлөвлөсөн төлөвлөгөөний дагуу дараахь хяналт шалгалтуудыг хийсэн байна. 1.Төлөвлөгөөт шалгалт: а).Шинэжинст, Гурванбулаг, Баянбулаг, Баян-Овоо, Бууцагаан, Хүрээмарал сумын улсын бүртгэгч нарын 2025 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хооронд хийсэн 213 бүртгэл (иргэний, хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн)-д хяналт шалгалтыг хийлээ. Тус хяналт шалгалтын дүнд буруу бүртгэсэн гэх 1 бүртгэлийг хүчингүй болгохоор хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргахаар бэлтгэж байна. б).Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2026 оны 01 дүгээр улиралд бүртгэгдсэн нийт бүртгэлээс 355 бүртгэлд хяналт шалгалт хийж, улмаар илэрсэн 2 зөрчлийг арилгуулсан. в).Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 2026 оны 01 дүгээр улиралд 685 бүртгэлд хяналт шалгалт хийсэн ба 15 зөрчил илэрснийг арилгуулсан. г).Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 43 бүртгэлд хяналт шалгалт хийсэн бөгөөд зөрчил илрээгүй байна 2.Төлөвлөгөөт бус шалгалт: Тус шалгалтыг нөхөн сонгуультай Галуут сумын улсын бүртгэгчийн бүртгэсэн шилжилт хөдөлгөөний бүртгэл, Баянхонгор сумын багийн засаг дарга нарын	60

1	2	3	4	5	6	7	8
						сонгуультай холбогдуулан Баянхонгор сумын улсын бүртгэгчийн бүртгэсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд тус тус хийлээ. Тус хяналт шалгалтын хүрээнд шилжилт хөдөлгөөний 369 бүртгэл шалгагдсан байна.	
3.2	Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулж батлах, хэрэгжилтийг хангах		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангах ажиллаж байна. Тус төлөвлөгөөнд 5 арга хэмжээ тусгагдсан болно.	60
<b>ЗОРИЛТ 4. ЧАДАХУЙН ЗАРЧИМД СУУРИЛСАН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЖ, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАНА.</b>							
4.1	“Хэлтсийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө 2026” боловсруулан батлах, хэрэгжилтийг ханган ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	95	100	“Хэлтсийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр төлөвлөгөө- 2026” боловсруулан хэлсийн даргын 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/08 дугаарт тушаалаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөнд заасан цаглабарын дагуу 2, 4, 5 дугаар сард орохоор батлагдсан бүх сургалтууд амжилттай зохион байгуулагдсан. Сургалтын хөтөлбөрийг 80/20 зарчмаар боловсруулсан бөгөөд сургалтын чанар, хүртээмж, үр дүн, өгөөжийг үнэлэх зорилгоор сургалтын дараа Google.form.doc-аар мэдлэгийн сорил, үнэлгээ авч, үнэлж дүгнэх ажлыг хэвшүүлж байна.	60
4.2	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.	-	Хэрэгжилтийн хувь	100	100	1.Хэлтсийн Хөгжлийн бэрхшээлтэй 2 албан хаагчийн ажлын ачааллаас үүдэлтэй бие мах бод сэтгэл санааны стресс ядаргаанаас урьдчилан сэргийлж, сэтгэл зүйн дэм өгөх зорилгоор хэлтсийн даргын 2026 оны А/10, А/11 дугаар тушаалаар ажлын цагийг 7 хоногийн 36 цаг болгон богиносгож, дэмжлэг үзүүлэв. 2.Хэлтсийн хамт олны уур амьсгалыг сайжруулах, байгууллагын соёлыг дэмжих зорилгоор хамт олны хурлаар шинээр хүүхэдтэй болсон, албан хаагч өөрөө эмнэлэгт хэвтсэн, эмнэлэгт аав ээж, эхнэр, нөхөр, хүүхдээ сахисан, ар гэрийн гачигдал гарсан тохиолдолд дундаасаа хуримтлал үүсгэн мөнгөн дэмжлэг үзүүлж байхаар тогтсон бөгөөд уг тогтсон журмын дагуу өнөөдрийн байдлаар 8 албан хаагчдад	60

1	2	3	4	5	6	7	8
						<p>хамт олны сэтгэлийн мөнгөн хандив (эргэлт) өгсөн байна.</p> <p>3.Төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор харилцаа, хандлага, ажлын үр дүнгээрээ бусдыгаа манлайлан, үлгэрлэн, сайн жишээ болж буй албан хаагчдыг магтан сайшаах, урамшуулах арга хэмжээг тухай бүрд нь зохион байгуулж байна. Тодруулбал, 2026 оны 1 дүгээр улиралд санал хүсэлтийн дэвтэрт иргэдээс хамгийн их талархал хүлээн авсан улсын бүртгэгч Д.Отгонсүрэн, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа шилдэг нягтлан бодогчоор шалгарч байгууллагын нэр хүндийг өргөсөн нягтлан бодогч Г.Бат-Очир, 2025 оны аймаг, сумын Хөдөлмөрийн аварга болсон улсын бүртгэгч Т.Мягмарсүрэн, Д.Мягмар нарыг хэлтсийн цахим хуудсаар алдаршуулан, аймгийн олон нийтийн сошиал цахим хуудсаар дамжуулан түгээж олон нийтэд танилцуулахын зэрэгцээ байгууллагаа сурталчилав.</p> <p>Хэлтсийн 10 албан хаагчаас Төрийн албан хаагчийн зэрэг дэв нэмэгдүүлэн олгож өгөхийг хүссэн өргөдөл ирснийг УБЕГ-ын даргад уламжлан танилцуулж, улмаар УБЕГ-ын даргын 2026 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн Б/108 дугаар тушаалаар 4 албан хаагч хаагчийн зэрэг дэвийг нэмж олгуулав. Одоо 6 албан хаагчийн зэрэг дэв нэмж олгох асуудал шийдвэрлэгдээгүй байна.</p>	
4.3	УБЕГ-ын 2026 оны сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.	-	Хэрэгжилтийн хувь	100	100	<p>“Сургалтын хөтөлбөр батлах тухай” Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/94 дугаар тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр 2025-2026”, уг хөтөлбөрийн хавсралтаар батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан хэлтсийн сургалтын төлөвлөгөөг дахин боловсруулж, даалгаврын дагуу хэлтсийн даргын 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 11/362 дугаарт албан бичгээр хүргүүлсэн байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	60

1	2	3	4	5	6	7	8
						Тус төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын агуулга, сэдвүүд хэлтсийн даргын 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/08 дугаарт тушаалаар батлагдсан “Хэлтсийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр төлөвлөгөө-2026”-д орсон сургалтын сэдвүүдтэй агуулгын хувьд таарч байгаа тул хэрэгжилтийг хангаж байгаа гэж үзсэн болно. Иймд гүйцэтгэлийн хувийг хэлтсийн сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувьтай адилтгаж үзэж болно гэж дүгнэж байна.	
<b>ЗОРИЛТ 5. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨР, ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР ДУНДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.</b>							
5.1	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих	-	-Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	93.2	100	Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу байгууллагад ирсэн өргөдлийг цаасан болон цахим ( ер) системд бүртгэлжүүлэн, хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 18 өргөдөл ирсэн. Үүнээс бүрэн шийдвэрлэсэн 16, судлагдаж буй 2 өргөдөл байна. Өргөдөл гомдлын сарын мэдээг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон сар бүр, харин улирлын мэдээ, тайланг улирал тутам тус тус гарган аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтэст мөн УБЕГ -ын холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна. Нийт ирсэн өргөдлийг субъектээр ангилвал, албан хаагчдаас ирүүлсэн 14, иргэнээс ирүүлсэн 4 өргөдөл, харин агуулгаар ангилвал албан хаагчид зэрэг дэв нэмэгдүүлэх, иргэдээс ирсэн өргөдлийн агуулга бүртгэлтэй холбоотой лавлагаа, тодруулга гаргуулах, бүртгэл хийлгүүлэхтэй холбоотой байна. Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн өргөдөл байхгүй байна. “Хугацаандаа буюу өдөртөө нээж хараагүй” гэх зөрчил 109 бүртгэгдсэн байх бөгөөд уг зөрчлийг дахин гаргахгүй байхад, өөрөөр хэлбэл, Өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ хуулийн хугацаанд багтаан шуурхай шийдвэрлэхэд гол анхаарлаа хандуулж байсан боловч ERP системд өдөр тутамдаа нээж харах горимыг таньж мэдээгүйгээс болж “хугацаандаа буюу	90

1	2	3	4	5	6	7	8
						өдөртөө нээж хараагүй” гэсэн зөрчлийг их гаргасан байна. Энэ алдааг дахин давтахгүй байхад анхаарч албан хаагч нарт егр системд өргөдөл, гомдол шийдвэрлэх, анхаарах асуудлын талаар сургалт орж, зөвлөгөө өглөө.	
5.2	Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн эргэлтэд хяналт тавих	-	Хугацаатай, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувь	95.3	100	Хэлтсийн хэмжээнд 2026 оны 06 дугаар сарын 02-ны байдлаар ирсэн 464, явсан 405, нийт 869 албан бичиг, Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаал, албан даалгавар, чиглэл, зөвлөмжтэй холбоотой 52 тус тус бүртгэгдсэн байна. Ирсэн, явсан албан бичиг болон өргөдөл, гомдлыг егр системд давхар бүртгэн хяналт тавин ажиллаж байна. Хэлтэст нийт 310 хариутай албан бичиг ирүүлсэн ба хуулийн хугацаа хэтрүүлэн буюу шийдвэрлэх хугацаандаа багтаан шийдвэрлээгүй албан бичиг 8, цахим системд ажлын 8 цагтаа багтаан нээж хараагүй 62 байна. ERP системд илэрсэн зөрчлийн талаар албан хаагч бүрээр зөрчлийг гарган, хамт олны хурлаар 2 удаа танилцуулж, анхааруулан, 2 дугаар улирлын байдлаар зөрчлийг 3-аас дээш давтан гаргасан албан хаагчдад холбогдох хариуцлага тооцохыг мэдэгдсэн болно.	97,4
5.3	Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандартын хэрэгжилтэнд хяналт тавих	-	Үйлчилгээний стандартын хэрэгжилтийн хувь	94.2	100	Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөн ажиллахыг анхааруулж байнгын хяналт тавин ажиллаж байна. Ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар ямар нэгэн зөрчил илрээгүй, гомдол мэдээлэл ирээгүй байна. Улсын бүртгэгч нарын суудаг үйлчилгээний 8 цонхонд үйлчлүүлэгч нараар бөглүүлэх сэтгэл ханамжийн судалгааг QR код үүсгэн байршуулж, судалгааг бөглүүлж байна. Уг судалгаагаар албан хаагчдын харилцаа хандлага, үйлчилгээний шуурхай байдал, зөвлөгөө мэдээллийг ойлгомжтойгоор өгч чадаж байгаа (ур чадвар) эсэх зэргийг үнэлэх асуултыг оруулж, хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандартад үйлчлүүлэгч нарын оролцоотой хөндлөнгийн үнэлгээний систем нэвтрүүлж байна.	100

1	2	3	4	5	6	7	8
5.4	УБЕГ-ын даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын бүртгэл хөтөлж, хэрэгжилтийг хангаж ажиллах		Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	90	100	УБЕГ -ын даргын зөвлөлийн, мөн өргөтгөсөн хурлаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр нь хүлээн авч хэрэгжилтийн ханган ажиллаж байна. УБЕГ-аас зохион байгуулдаг удирдлагын болон өргөтгөсөн шуурхай цахим хуралд тухай бүр нь бүрэн оролцсон. УБЕГ-ын даргын болон шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь <a href="mailto:naranchimeg.a@burtgel.gov.mn">naranchimeg.a@burtgel.gov.mn</a> хаягаар хүргүүлэн ажиллаж байна. Мөн хэлтсийн 7 хоног бүрийн үйл ажиллагааны товч танилцуулга мэдээллийг Баасан гараг бүрийн өдрийн 12:00 цагаас өмнө өгсөн чиглэлийн дагуу vibeg хаягаар хүргүүлэн тайлагнаж байна.	100
5.5	Төрийн албан хаагчийн сахилга бат, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт болоод нөлөөллийн ажлыг зохион байгуулах		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь			1.Хэлтсийн 2026 оны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа” бүлэг сэдвийн хүрээнд 15 кридетийн 25 цагийн сургалт орохоор төлөвлөгдсөн ба уг төлөвлөгөөний дагуу 1, 3, 4 сард орох 9 цагийн сургалт бүрэн зохион байгуулагдсан байна. 2.Нөлөөллийн ажлын хүрээнд авах арга хэмжээний эхний алхам бол албан хаагчдын стресс, ажлын ачаалал, харилцаа, дарамт, дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, сэтгэл ханамж зэрэг үзүүлэлтийг <b>тоо хэмжээгээр үнэлж</b> , эрсдэлийг тодорхойлж, цаашид сайжруулахад чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах явдал юм. Үүний илрэл болгож “Ажлын байрны сэтгэл зүйн орчны нэгдсэн судалгаа”-г Google.form.doc -аар авч, дүгнэлт хийж байна. 3.Төлөвлөгөөнд тусгагдсан чухал арга хэмжээний нэг албан хаагчийн ёс зүйн зөрчлийн эрсдэлийг үнэлж, ёс зүйн зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулах. Үүний хүрээнд “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний хуудас”-ыг 2026 оны 03 дугаар сарын 27-нд бөглүүлж авсан ба уг үнэлгээний хуудсыг дүнг нэгтгэж дүгнэх ажлыг хийж байна. Мөн ХЗДХЯ-наас 05 сард зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн	60

1	2	3	4	5	6	7	8
						үнэлгээний хуудас"-ыг бөглүүлэх ажилд албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулсан ба уг судалгаанд 32 албан хаагчийг хамруулсан байна.	
5.6	Байгууллагаас сар бүр үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх	-	Сар бүрийн тоон мэдээг байршуулсан тоо	12	12	Иргэний, хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн сар бүрийн тоон мэдээг инфографик бэлтгэн байгууллагын цахим хуудас bayankhongor.burtgel.gov.mn вэйб болон нээлттэй фэйж хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж байна. Мөн бүртгэлийн тоон мэдээг 1 дүгээр улирлын байдлаар нэгтгэн инфографик мэдээлэл болгон бэлтгэж олон нийтэд хүргэв. Мөн хэлтсийн ил тод мэдээллийн самбарт 6 удаа байршуулсан байна.	100
5.7	Байгууллагын үйл ажиллагааг цахим, фэйсбүүк хуудсаар болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, телевиз радиогийн нэвтрүүлэгт оролцох	-	Сурталчилсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн төрлийн тоо	4	4	Хэлтсийн үйл ажиллагааг сурталчилан таниулах чиглэлээр байгууллагын вэйб хуудас болон фэйсбүүк пэйж хуудсууд, үйлчилгээний зааланд мэдээллийн самбаруудыг тус тус ажиллуулж байна. Эхний хагас жилийн байдлаар өөрийн байгууллагаас нийт 217 мэдээ мэдээллийг байршуулсан байна. Үүнд өөрийн байгууллагаас бэлтгэж байршуулан мэдээлэл 100, УБЕГ-аас бэлтгэн гэсэн мэдээ мэдээлэл 44, аймаг орон нутаг болон бусад байгууллагаас бэлтгэсэн мэдээ мэдээлэл 73 байна.	70
			Олон нийтэд сурталчилсан мэдээ мэдээллийн тоо	608	310		
5.8	Аймгийн ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллах		Хамтран зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	3	1.Аймгийн ИТХ болон Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс зохион байгуулж буй "Хонгорын хөгжлийг түүчээлье" аяны удирдамжийн дагуу холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу ажиллаж тайланг, аялах тугийн хамтаар 05 дугаар сарын 15-ны өдрийн 16.00 цагт дараагийн байгууллагад хүлээлгэн өгөв. Мөн ИТХ-аас зохион байгуулж байгаа "Хуулиа мөрдье" аянд нэгдэж, удирдамжийн дагуу Цахим залилан, залилах гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх, Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. 2.Аймгийн ЗДТГ-с 14 хоногт 1 удаа зохион байгуулдаг удирдах ажилтны шуурхай хуралдаанд хэлтсийн дарга	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>тогтмол оролцож мэдээлэл авч, авсан мэдээллээ албан хаагчдад тогтмол хүргэв.</p> <p>3.Баянхонгор сумын Засаг даргын захирамжийн дагуу сар бүрийн 2,12-ны өдөр зохион байгуулагддаг "БҮХ НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ"-нд идэвхитэй оролцож, хуваарьт газар болон байгууллага орчимын хог хаягдлыг цэвэрлэж, өөрийн хариуцсан талбайн модны ургалтын хувийг тодорхойлж амьдрах чадваргүй болсон 25 модыг нөхөн тарьж, усалгаа арьчилгааг хийж гүйцэтгэж энэ талаарх мэдээллийг хэлтсийн цахим хуудсанд тухай бүрд нь байршуулж, түгээлээ.</p> <p>4.Аймгийн "Боловсролыг дэмжих жил"- ийн зорилтод арга хэмжээг дэмжин зохион байгуулагдаж буй "Суралцагч аймаг-2026" төслийн "Хуулиа дээдлэе" зорилтод арга хэмжээний хамтран зохион байгуулагчаар оролцож, төлөвлөгөөний дагуу 3-р сард Гэр бүлийн эрх зүйн харилцаа-Иргэний улсын бүртгэл, 4-р сард Гэр бүлийн эд хөрөнгийн эрхийн харилцаа-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл,5-р сард Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр тус тус сургалтуудыг амжилттай зохион байгууллаа. Сургалтад "суралцагч- байгууллага", "суралцагч-гэр бүл", "суралцагч- сурагч" гэсэн зорилтод бүлгүүд хамрагдлаа.</p>	
5.9	Байгууллагын тусгай төрлийн баримтыг Төрийн архивт шилжүүлэх	-	Заасан хугацаанд бүрэн шилжүүлсэн баримтын тоо	1	1	Хугацаа болоогүй буюу 4 дүгээр улиралд төлөвлөгдсөн байна.	-
5.10	Төрийн архивын хэлтсийн сан хөмрөгт 2023 оны цаасан болон цахим баримтыг дансны хамт бүрэн бүрдэлтэй шилжүүлэх	-	Хугацаанд нь шилжүүлсэн хувь	100	100	Төрийн архивын хэлтсийн сан хөмрөгт байгууллагын 2023 оны цаасан болон цахим баримтыг дансны хамт бүрэн бүрдэлтэй шилжүүлэх ажлыг 5 сард багтаан дуусгав. Үүнд зөрчлийн хэрэг хялбаршуулан журмаар шийдвэрлэсэн баримт 479 нэгж, байгууллагын удирдлагын болон санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 40, нийт 519 нэгж баримтыг хүлээлгэн өгсөн байна.	100

1	2	3	4	5	6	7	8
<b>ЗОРИЛТ 6. САНХҮҮ, ТӨСВИЙН УДИРДЛАГА БОЛОН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.</b>							
6.1	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байдалд хяналт тавих	-	Хугацаандаа байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо	147	147	Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын холбогдох тогтоолын дагуу байгууллагын санхүүгийн мэдээллийг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> , сайтад сар бүр тогтмол байршуулан 84 удаагийн мэдээллийг шинэчилсэн, мөн <a href="http://www.bayankhongorburtgel.com">www.bayankhongorburtgel.com</a> сайтад нээлттэй мэдээллийг тогтмол байршуулсан бөгөөд 10 удаагийн мэдээллийг шинэчилж байршуулсан байна.	100
			Хуулийн хэрэгжилтийн хувь	98,6	100		
<b>ЗОРИЛТ 7. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨР, ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР ДУНДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.</b>							
7.1	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2026 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.		Албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж олон нийтэд хүргэсэн тоо	38	78	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2026 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэрэг 17 төрлийн мэдээллийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээнд байршуулсан бол харин байгууллагын мэдээллийн самбарт 5 төрлийн мэдээллийг байршуулан сурталчиллаа. Мөн хэлстийн зүгээс 2 төрлийн постер бэлтгэн, байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтийн социал хуудсанд хуваалцаж, түгээсэн байна. Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр: 1.Авлигын эсрэг хууль, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн дүрэм зэрэг хууль тогтоомжийн хүрээнд "Авлига, ашиг сонирхлоос сэргийлэх" сэдвээр аймгийн Прокурорын газрын хяналтын прокурор Б.Байгалийг урьж, 01 дүгээр сарын 13-ны өдөр, мөн аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ээс "Нийтийн албан тушаалтнуудын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх цахим сургалт зохион байгуулах хөтөлбөр"-ийн дагуу 01 дүгээр сарын 09,	60
			Хэлтсээс энэ чиглэлээр бэлтгэсэн контентийн тоо	2	4		
			Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан хувь	100	100		

1	2	3	4	5	6	7	8
						15, 22-ны өдрүүдэд зохион байгуулсан цахим сургалтад, мөн 02 дугаар сарын 11-нд Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс ёс зүйн хэм хэмжээ”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” сэдэвт сургалтуудыг цахимаар, 03 дугаар сарын 26-нд албан хаагчдын нэгдсэн сургалтаар “Төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалт, хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан байна. Эдгээр сургалтад хэлтсийн албан хаагчид танхимаар сумдын улсын бүртгэгч нар цахимаар бүрэн хамрагдаж, сургалтын дараахь сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдлаа.	
7.2	Үйлчилгээний зааланд хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлэх тэмдэг, тэмдэглэгээнд нэмж сонсголын бэрхшээлтэй иргэн гэх таних тэмдэг болон “Тусламжийн хонх”-ыг байршуулах	-	“Таних тэмдэг” байршуулсан тоо	0	1	Үйлчилгээний зааланд хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлэх тэмдэг, тэмдэглэгээнд нэмж сонсголын бэрхшээлтэй иргэн гэх таних тэмдэг болон “Тусламжийн хонх”-ыг байршууллаа. Тусламжийн хонх байршуулсан тухай Илтгэх хуудсыг хэлтсийн даргын 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 11/146 дугаарт албан бичгээр тайлагнасан байна.	100
			“Тусламжийн хонх”-ийг байршуулсан тоо	0	6		
7.3	Хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт иргэдэд зөөврийн тоног төхөөрөмжөөр явуулын үйлчилгээ үзүүлэх		Үйлчилгээ үзүүлсэн хувь	100	100	Улсын бүртгэлийн 4G төхөөрөмж ашиглан явуулын үйлчилгээг иргэдийн хүсэлтийн дагуу гэрээр болон эмнэлэгт (газар дээр нь) 60 иргэнд үзүүлсэн бөгөөд үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 27 иргэнд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.	100
7.4	Гамшгаас хамгаалах бэлэн байдлын улсын үзлэгт бэлтгэх, хэрэгжилтийг хангах		Хэрэгжилтийн хувь	-	100	Гамшгаас хамгаалах бэлэн байдлын улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд хэлтсийн 2026 оны А/15 дугаарт тушаалаар гамшгийн болон галын аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг томилж, эрсдэлийн үнэлгээг хийлгүүлсэн. Мөн мэргэжлийн ангийн жагсаалтын 2 удаагийн үзлэгт албан хаагчдыг бүрэн хамруулж, хувцас хэрэглэл, аранзыг жигдрүүлэх ажлыг зохион байгуулав. Аранзны үнэ болох 1.620.000 төгрөгийг Үйлдвэрчний эвлэлийн гишүүний татварын хуримлалтаас гаргуулан шийдвэрлэв. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын	70

1	2	3	4	5	6	7	8
						<p>үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд галын хорны техник хяналтын дэвтэр, таних тэмдэг зэргийг шинэчилэв.</p> <p>Мөн шаардлагатай байгаа галын хорны судалгааг гарган, санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр ерөнхий газарт хэлтсийн даргын албан бичгээр хүсэлт, мөн 2027 оны төсвийн төсөлд тусгуулахаар саналаа хүргүүлсэн байна.</p> <p>Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг бэлтгэн аймгийн Онцгой байдлын газарт хянуулахаар хүргүүлээд байна.</p>	
<b>7.5</b>	Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдлээс хамгаалах төлөвлөгөө батлаж хэрэгжилтийг хангах		Үнэлгээ хийгдсэн хувь	-	100	Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг хэлтсийн даргын 2026 оны А/15 дугаарт тушаалаар томилж, эрсдэлийн үнэлгээг 2026 оны 04 дүгээр сард хийлгүүлсэн.	80
			Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100		
						Төлөвлөгөөнд 12 арга хэмжээ тусгагдсан байна.	